

ДАЙНД ОРОЛЦСОН ТУХАЙ ДУРСАМЖ

НЭГ. 1945 ОНЫ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ОРОЛЦСОН МИНЬ

Би 1943 онд ЗХУ-ын Дотоод явдлын ардын комиссариатын Ф.З.Дзержинскийн нэрэмжит Харьковскийн хилийн цэргийн дунд сургуулийг төгсгөж ирээд ДЯД-ны дотоодын ба хязгаарын цэргийн нэгдсэн сургуульд багш, штабын даргын ажлыг 1951 оны 9 дүгээр сар хүртэл хийсэн юм. Энэ хугацаанд дээрх сургуулийн суралчдыг хил хязгаарт дадлага хийлгэх ажлыг бараг жил дараалан удирдаж, хил хамгаалах ажлыг биечлэн хийж байв. 1945 онд тус сургуулийн хил хамгаалчдыг Халх голын 24 дүгээр отрядад дадлага хийлгэж байхад японы эсрэг чөлөөлөх дайн болов.

Би отрядын улс төрийн орлогч Балжинням агсны хамт заставуудаар явж ажиллаж байв. Тэр үед зөвлөлтийн цэргүүд баруун фронтоос татагдан манай хилийн дагуу байрлаж, японы эсрэг дайнд ороход бэлтгэж байсан юм. Халх голын районд Беларусьийн 3 дугаар фронтын цэргүүд байсан бөгөөд тэд маш ширүүн долошин, дайны галын дунд явж санаа сэтгэлээр унасан, ёс суртахууны хувьд ихээхэн эвдэрсэн дайчид байсан. Энэ учраас заставын хонь, мал, ялангуяа тугалыг алж идэх дуртай, нутгийн айлуудын болон заставын тугалыг бэлчээрээс нь ангидаа аваачиж иддэг, энэ тэрийг ярих юм бол бу гарган хий буу тавьж сурдүүлэх зэргээр айлгадаг байлаа. Тэр байтугай өөр хоорондоо буудалцаж байсан.

Манай заставын дарга, цэргүүд орос хэл мэдэхгүй, оросууд монгол хэл мэдэхгүй учир хэл амаа ололцох нь түвэгтэй байв. Сүүл сүүлцээ оросуудын булааж авсан малын төлөө ярилцдаг хүн бол бэл болж хувирав. Эхний үед тэд буулт хийхгүй, авсан малаа буцаа өгөхгүй, юм л бол буу гаргадаг байсан ба би ч бас буугаа гарга айсан сурдсан шинжгүй байвал арай дээр байдаг байсан юм. Гэтэл дугаар сарын сүүлчээр орос цэргийн нэг дивизийн штаб Нөмрөгийн заставт байрласан учир дивизийн дарга хошууч генерал Палчанов улс төрийн хэлтсийн дарга Южеков нартай дотно танилцаж малт дээрэмтэй тэмцэхэд би "хүчтэй" хүн болсон юм.

Би 1945 оны 8 дугаар сарын 7-нд Нөмрөгийн урд заставт байхад байтал дивизийн дарга Палчанов нэн даруй уулзахыг хүсч заставыг

хөлболоогоор дуудав. Балжинням бид хоёр Нөмрөгийн заставт очиж Палчановтой уулзгал: Тэр "... шөнийн 00 цагт дайнд орно. Маргааш тавь заставыг япончууд бөмбөгдөж их буугаар буудна байх. Та нар шөнийн турш гүн окол малтаж, хориглон хамгаалалтыг сайн хийнэ" хамт заставын мал, гэр бүлийн хүмүүсээ гүнд холдуулах "сэтгэл..." гээд дайн зарлаж В.М.Молотовоос хэлэх үг, Москвад байгаа японы элчин сайдад гардуулах ноот бичиг зэргийг үзүүлэв. Энэ тухай отрядын дарга баатар Чогдонд мэдэгдэж генералын ёсоор бүгдийг хийж шөнийг өнгөрөөв. Үнэхээр шөнийн 00 цаг болж цэвлөлтийн цэргийн онгоцууд үй олноор зүүн зүг одож Нөмрөгийн заставын хойд талаар Халхын голд резин гүүр тавьж танк-иэрчилсон анги Дорныг чиглэн явж дайн эхлэв. Гэтэл өглөөний 4 орчим орос цэргийн нэг дэд хурандаа, дэслэгч, 2 цэргийн хамт генерал Палчанов ирж улмаар генерал Палчановтой уулзуулав. Энэ үеэртэй байна. Зэргэлдээ ангиуд нэлээд урагшлав бололтой. Манай баглан цэргүүд гол гарч чадахгүй байна. Ах дүүгийн ёсоор та манай туслахыг хүсэж байна..." гэв. Дайсан этгээд харагдахгүй, манай адилгүй байсан учир Палчанов бухимдсан байдалтай байв. Балжинням бид хоёрын дэргэд салбар ангиудын командлагч нарыг "Палчан" ... Бидний өөдөөс буудах хүч байвал бууддаг, далдалсан буугаа ил гаргаад зүүн уулын хаяанаас дороос нь дээш нь явж Халх голын дээгүүр бууд..." гэж тушааж байв. Генерал ёсоо бол Украин хүн байсан байх. Тэр сайн зам (дорооха) тэж, шууд замаар явж том хүчтэй тулалдахсан гэж бид нарт байв. Бид заставтаа эргэж ирээд Нөмрөгийн заставын морьдыг дэвчээд цэрэг, төв сургуулийн 5-6 суралчдыг оролцуулан төв цэргийн сумангийн улс төрийн орлогч Бираадамба, отрядын дарга Банди, заставын дарга Тогтог, улс төрийн орлогч наараар толгойлуулан бүлгүүд зохион байгуулж зөвлөлтийн цэргүүдийг мориор гол гаргаж эхлэв. Орос цэргүүдийн олонхи нь үзээгүй учир сэлж байгаа моринь амьт татан хөл алдаж явж байв. Энэ учраас орос цэргүүдийг морь унуулж дэл, морь нь барилдан усны гармыг алдахгүй даган, өөрсдөө хөтлөн морьтын зэрэгцээ хүнд, хөнгөн пулемёт, миномёт, дайзтай сум бид өөрсдөө гол гаргаж байв. Өглөөний 5 цагаас 14 цаг хүртэл 2 батальоныг гол гаргалаа гэж оросын дарга нар хэлж байв. Тэд бид нарт маш их баярлаж, зүүж явсан буу, дуралгаа гаргаж байв. Бид дайнд явж байгаа нөхдөөсөө юм авахгүй гэж боловч тэд шууд зүүж өгч байсан юм. Намрын морьд тарган

Боловч олон дахин ус туулахаар дорхноо ядарч байсан. Түүнээс гадна голыг хэд туулмагц манай үйлдвэрийн цэрэг эмээлийн наалт дэвтэн хэдэн хэсэг салж байсан тул сүүлдээ бид зайдан мориор ус туулж байсан юм. Тэр хавьд байсан цэргүүдийг гол гаргаж дуусмагц генерал Палчанов "...Бид зэргэлдээ ангиасаа нэлээд хоцров. Дайсантай нүүр учирч тулалдах юмсан. Та нар морьтойгоороо явган цэргийн өмнө явж дайсан ойр байгаа эсэхийг тагнаж өгнө үү..." гэв. Бид зөвшөөрч Балжинням бид хоёр тус бүр 7 цэрэгтэй 2 бүлэг болон явган цэргийн өмнө явж тагнуул хийв. Чингэхэд япон, баргын жижиг ангиуд байраа хаяж зугтаасан байв. Харин тэдний байрны галын цог унтраагүй байсан тул холдоогүй байгаа нь илт байв. Бид япон, барга цэргүүдийн хаяад зугтсан радио станц, тамхи, чуу, амьд гахайг олзлон авч оросуудад авчирч өгөв. Тэр өдөр зөвлөлтийн цэргүүд маш хурдтайгаар урагшлан хилийн ойр хавьд байсан дайсны хэсэг бүлэг цэргүүдийг устган Манжуурын нутагт байгаа Халуун рашааны зүг давшиж тэнд нэлээд тулалдаан болов. 8 дугаар сарын 10-ны өглөө дивизийн штаб гол гарч нүүж эхэллэл Халх голын зүүн эрэгт Нөмрөгийн заставын чигт байгаа хоёр өндрийн оройноос пулемёт, автоматаар мөндөр орох шиг шуршиж гарав.

Штабыг хамгаалж байсан бололтой нэлээд цэргүүд байсан бөгөөд тэд уулын оройд байгаа дайсантай байлдаж түүнийг эзлэх болов. Бид ч оросуудын хамт давшиж. Оросууд тэр уулын оройг их буу. 82 мм-ийн миномётгоор 30 минут хэртэй буудсан тул уулын орой тэр чигээрээ тэнгэрт гарч байгаа мэт шороо, утаа тоос болж байв. Тэр завсар орос цэргүүд давшиж дайсны галын цэгт бараг тулж атакт орсон ба тэр цэгт дайсны 22 хүнээс хоёрхон цэрэг амьд үлдсэн байсан авч, орос цэргийн өмнөөс эсрэг атакт орж гранат шидэн босож ирж байсан нь япон цэрэг дээд газрын шийдвэргүй бууж өгдөггүй гэдэг үнэн мэт санагдсан.

Орос цэргүүд уулын оройн галын цэгийг эзлэн аваад ороход тал бүртээ олон суваг шуудуутай цементээр бэхэлсэн 20 гаруй хүн амарч унтах байртай, монгол дээл болон бусад хувцас, хоол хүнсний нэлээд нөөцтэй байв. Энэ мөчийн дараа генерал Палчанов намайг дуудан ихэд баярласнаа хэлж "...Та нарыг Зөвлөлт засгийн газраас шалгах ёстой. Дайн тулалдааны энэ хэцүү үед холбоо харилцаа тогтвортой барьж чадахгүйн улмаас ийм сайхан нөхдийг хоосон үлдээвэл муу юм болно. Иймд бааратгүйгээр нь би маршал Чойбалсанд та нарыг шагнах тухай бичиг хийж өгнө. Маргааш та нар хилийн чанадад 18 км-т байгаа Халуун рашаанд очиж уг бичгийг авна уу" гэв. Бид маргааш нь Халуун рашаанд очиж бичиг авахад Ц.Дэмиддагва, Балжинням, төв

сэргүүлийн сумангийн улс төрийн орлогч Бираадамба, отрядын тасгийн дарга Банди, заставын дарга Тогтог, улс төрийн орлогч Бааврсад, төв сүргүүлийн 5 сурлагч, заставын 5 цэргийн нэрийг оруулан Халх голыг гатлах болон тагнуул хийж байлдааны үүрэг гүйцэтгэн ах эмгийн халуун тусламж үзүүлсэн эдгээр хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнаж өгөхийг хүсье" гэсэн бичиг байв.

"Гэгэл отрядын төв дээр ирэхэд тэр бичгийн тухай сураг дуулсан Чогдонгийн сурлагч орос дарга нөгөө бичгийг та нар Маршалд өгөх биш би өгөх ёстой гэж авахыг шаардав. ...Бид өөрсдийгөө шагнана гэж бичиг өгснөөс зөвлөлтийн энэ хүн өгөх нь зөв байх. Энэ бичгээ өгсөн юм. Тэр сурлагч Балжиннямыг үзэн яддаг хүн байсан. Тэгээд ч юм уу уг бичиг сураг чимээгүй алга болж хаягласан гэдгээ хүрээгүй юм. Харин энэ бичгийн тухай генерал Б.Цэдэн-Иш, 25 жилийн ойгоор 1970 онд Балжинням бид хоёрыг зөвлөлтийн "Хөдөлмөр" медалиар шагнасан явдал бий.

Албан үүргээ гүйцэтгэхийн хамт дээд газрын шийдвэргүй зөвлөлтийн нөхдөд тус хүргэж явсан явдал бол пролетарийн интернационализм гэгчид үнэнч, монгол-зөвлөлтийн найрамдлын тусал зүтгэж, ЗХУ түүний армийг манай ард түмнийг аврагч гэж итгэсэн зэргээс өөрийн амь биеийг хайрлахгүй явсны үлгэр болон үлдэх биз ээ.

Өнгөрсөн 50 жилд дэлхий дахинд болон Монгол-ЗХУ, Монгол-БНМАУ харилцаанд том өөрчлөлт гарлаа. Зэвсэг барин байлдаж явсан цэцэг барин золгодог болжээ. Түүгээр ч барахгүй дайсан гэж байсан япончууд Монголд тусламжийн гараа сунгаж байв. Энэ бол улиран өнгөрөх цаг хугацаа айл зэргэлдээ, нэг тивийн нэгдэлтэй байхаас аргагүй улам улам нотолсоор байна.

Монголчууд чадал нь хүрдэг бол шударга үйлсэд хувь нэмрээ оруулж хичээж явдаг үндэстэн билээ. Эх орны их дайны жилүүдэд армийн армид чадлынхаа хэрээр тусалж Дорно дахинд дайны үнтраахын тул өөрийн зэвсэгт хүчээр оролцон Нэгдсэн Сталийн баттай зогсож, ахан дүүс Өвөр Монгол, Хятадын зүүн бүсийг чөлөөлөхөд багалуй хувь нэмэр оруулсан юм.

ОРОЛЦСОН МИНЬ

аюлтай болгов.

хүрлэх, хэлтэсний туслах зэрэг үйлдвэр хувьцаа бүхий хөрөнгийн эзэмшүүлж байгаа бөгөөд түүнийг хувиартайгаар зарцуулж байна.

нэрэмжит харьякын тухай дурсан өгүүлсү

Москвагаар дайран 10 дауны нөхт
-52

ИЗДАНИЕ ИЛТ БАЙВ.

Эсрэг ажил хийдэг байв.

... ..

давж ойлсан хэрэг юм. Шүүхээр бусан дайсныг

илрүүлэхэд моринд гарамгай монгол сурагчид түргэн жагсаалын дохиогоор хамгийн түрүүн морин эмээлэж, тэргүүн шугаманд давхин одож, хүрэх газраа түргэн очиж, хаах ёстой зам, зэлэх ёстой цэгийг нэн тэргүүнд эзэлдэг байсан бөгөөд бусад сурагчид, цэргүүдээс ялгарч сургуулийн командлалаас нэг бүс удаа талархал, сайшаал хүлээж байсан юм. Харин байрандаа байсан агт морьд маань онгоцноос буудсан сум, бөмбөгний дэлбэрэлт, хэлтэрхийд өртөж шархадсан, үхсэн тохиолдолд бид маш их гүнигтай байдалд орж, нулимсаа цувуулж байсан нь монгол хүний малдаа хайртайн тэмдэг байсан биз ээ. Фашистууд бол энэрэх сэтгэлгүй хүн төрөлхтний түүхэнд үнэхээр хар мөрөө үлдээсэн амьтдад гэдгийг бид нүдээр үзсэн. Фронтын шугам ойртсон үед хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан голдуу нутгийн ард түмэн явган нүцгэн, ганц хоёр үнээ малга тууж, сайндаа ганц нэг морин тэргэн дээр хувцас хунар, ганц хоёр өдөр гол зогоох хоол, хөнжил дэвсгэрээ ачаад эрхбиш гүнд орохоор зүүн зүгийг чиглэн явж байхад нь нисэх онгоцоор маш нам өндөрт нисч, племётоор шуршин засмал зам улаан нэгий болж байсныг санахад одоо ч зүрх шимширдэг. Энэ бүгдийг хараад дайснаас шөөгөө авахыг чармайж байв. Монгол хүн "цусаа үзээд улайрдаг" гэдэг ардын ажиг үг үнэн гэж би боддог. Тэр үед манай сургууль хот дүүрэг, районы дарга, багш, шүүгч мэргэжилтэй, дээд боловсролтой хүмүүсийг сурагчаар авч, дунд сургуулийн ахлах ангийн сурагчид, хамтралын залуу ажилчдыг цэрэгт татаж цэргийн мэдлэгтэй болгох, ялангуяа тэднийг буу зэвсэг эзэмших, биеийг чийрэгжүүлэн гардан тулалдаанд сургаж ажил хийж байсан бөгөөд монгол сурагчид бид цэргийн боловсролтой, зэвсэг техникийг эзэмшсэний хувьд тэднээс давамгайлж байсан юм. Энэ учраас сургуулийн дарга багш нар биеийн хөдөлмөрийн ажил, сургууль хийхэд орос цэргүүдийг монголчуудаар ахлуулж байсан юм.

Фронтын шугам нэн ойртсон 9 дүгээр сарын сүүлчээс байдал улам хүндэрч "дайснаасаа дажин" гэдэг болж, хүн ардын санаа сэтгэл тогтворгүй, энд тэнд дээрэм, тонуул, хүчирхийлэл газар аван аюул улам ихэсч, амьд үлдэнэ гэдэг ямар ч баталгаагүй байв. Бид ийнхүү бүтэн гурван сарын турш хувцсаа ч бүрэн тайлж унтаагүй, санаа сэтгэл, биеийн зовлонг эдэлж өнгөрөөсөн юм.

Энэ хэцүү үед сургуулийг гүнд нүүлгэх бэлтгэл ажил оров. Сургуулийн захиргааны шийдвэрээр монгол сурагчдын гурва дарга Л.Бэгз, Т.Ишжамц, Ц.Дэмиддагва нар болон бусад монгол сурагчид сумангийн шинэ цэргүүдийг удирдан сургуулиас авч нүүр эд материал, сургалтын хэрэгслийг боож баглах, нууцлах баримт

баримтууд болон дайсны гарт үлдээх ёсгүй эд агуурыг устгаж байв. Ийнхүү сургууль нүүхээр удаа дараа завдсан авч дайсан галт тэргэний өртөөг зогсоо зайгүй бөмбөгдөж байсан тул хэд хэдэн удаа хойшилж, хотын захад их буун дуу нийгнэнэ. Харьков бүрэн эргэж дэхээс нэг хоногийн өмнө арай чарай гарсан юм.

Галт тэргэний эхний цуваа дайсны эзэлсэн өртөөнд орж баригдсан нь манай цуваа байдлыг мэдэж ухран зугтаж, тойруу замаар мэнд бархад явдал бий. Бид ийм байдлаар Ростовт ирэхэд немчууд хотын сургалалтыг сэтэлж байсан боловч хотыг шууд эзэлж чадаагүй юм. Бид тэнд 7 хоног болоход ихэвчлэн гудамжны хоргодох байранд байж гудамжны хаалт хамгаалалтын ажлыг хоногт 20-22 цагаар хийж байв. Мөн галын шугамнаас янз бүрийн унаагаар ирсэн шархадсан цэргүүдийг дамнауургаар эмнэлэг, сул байшингуудад зөөж байв. Тэр үед биднийг бэлтгэл ангиас шууд фронтод шилжүүлсэн тул хүн бүр морин хаягаа цамцандаа бэхлээд тулалдаанд орох болов. Гэхдээ бид фронтын шугамнаас шархадсан цэргийг зөөж байсан. Хажуу хавиргаар нь шунгинаж, их бууны сум, бөмбөг дэргэд дэлбэрч байсан боловч бид амьд гарсан юм. Дараа нь удалгүй ухралт үргэлжилсэн. Бид фронтоос Каспийн тэнгисийн баруун эргийг даган явсаар Бакуд ирж багасч дээд командлалын тушаалаар Бакугаас Красноводск хотод усан онгоцоор явахдаа сэжиг бүхий немчуудийг хуяглан бархалцаж хүргэсэн. Красноводскоос ачааны вагоноор Каракумын галт таллан Ташкентад ирж сургуулиа үргэлжлүүлсэн юм.

Ташкентад ирмэгцээ Полтрацкий гэдэг тосгонд газар тэр "землянк" барих, буудлага, биеийн тамирын талбай, хоолны газрыг барих зэрэг ажлыг эхлүүлж байв. Мөн хамтралын ургац хураах, цэвэрлэх ажлыг хийхийн хамт багш дарга нарынхаа хамт морин эргүүлд гарч ард түмний амгалан тайван байдлыг хамгаалж ажилд оролцож байв. Тэр үед Поволжоос ирсэн немчууд, ирмэгцээ ирсэн солонгосчууд үе үе эмх журамгүй байдал дэгдээж байсан бөгөөд түлшүүртэй байсан юм. Үүнээс гадна тэр үед бүтээж байсан Сулбаатар киноны олон нийтийн дүрд оролцож, уранхай байсан монгол дээл өмсөж, олон цагаар чийдэнгийн гэрэлд шарагдан байрлуулдаг байв. Тэр киноны олон нийтийн дүрд манай олон сурагчид байгаа ба нэлээд тод гарсан нэг зураг бол Дэмбэрэлийн зураг. Энэ зураг Сю шу-жаний хажууд бараа болон Монголын том ноёд, сурагчид зурагд орж ирдэг юм.

Энэ үеийн ийнхүү сурч офицер болоход Харьковский хилийн цэргийн захирал багш, дарга нар бид нартай жаргал зовлонгоо хамт монголын ард түмэнд тус хүргэж Монгол улсын хил

хязгаарыг хамгаалах дарга боловсон хүчин бэлтгэхэд халуун сэтгэл зүтгэлээрээ чармайн ажилласан гавьяатай хүмүүс билээ. Бидний өмнө болон дараа суралцсан суралцадаас зөвхөн хил хамгаалахад ч төдийгүй улс, олон нийтийн байгууллагын салбарт нэр хүндтэй ажилласан хүмүүс олноор тодорсон юм.

Тухайлбал, бидний өмнө суралцсан хөдөлмөрийн баатар, генерал Ж. Жамьян, бидний дараа тус сургуулийг төгссөн гавьяат багш Дармаа, БХЯ-ны сайд агсан генерал Авхиа нарыг нэрлэж болно.

Эх орны их дайны хүнд бэрх цагт суралцсан бидний 29 хүн 1943 оны 3 дугаар сард Ташкентад сургуулиа төгсөж эх орондоо ирсэн. Биднийг ирмэгц маршал Х. Чойбалсан, ЗХУ-ын элчин сайд Иванов нар хүлээн авч хүнд үед тэсвэр хатуужилтай сурч хоёр орны ард түмэн хилчдийн найрамдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсныг тэмдэглэн бас бидний ядарч зүдэрч байсныг анхаарч хэдий дайны үед дарга нарт амралт өгдөггүй байсан ч бид нарт 45 хоногийн амралт өгч цай тамих, сарын цалингаар шатнаж байсан билээ.

Бид сургуулиа төгсөж ирээд хилийн цэргийн олон анги салбаруудад томилогдон нэр төртэй ажилласан юм.

Гэвч энэ завсар хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн 23, одоо сэрүүн тунгалаг байгаа 7 хүн байна. Бидний дотор онц сурч, эх орныхоо нэг төрийг хайрлан, нийтийн дайсантай тэмцэх хэрэгт хувь нэмэр оруулж ялангуяа улсын хил хязгаарыг хамгаалах, энх цагийн хөдөлмөрт зүтгэсэн гавьяатай хүмүүс олон бий. Тухайлбал, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Б. Цэвэгдорж, Л. Бэгз, Аюушийн Намжил агсан, мөн Монголын уран зохиолын санд шүлэг зохиолоороо хувь нэмэр оруулсан Амгагийн Самбалхүндэв агсныг дурсан тэмдэглэж байна. Биднийг суралцаж байхад хамт байсан буюу багшилж байсан хүмүүсээс одоо сэрүүн тунгалаг байгаа хүмүүс өдрийн од шил болжээ. Нөгөө талаар тус сургууль эхлээд Харьковоос Ташкентад дараа нь Ташкентаас Алма-Атад, дараа нь Москвад нүүсэн зэрэг архивын материалыг бүрдүүлэх явдал түвэгтэй болжээ.

Гэвч Харьковын хилийн цэргийн сургуульд биднийг суралцаж байхад сургуулийн улс төрийн хэлтэст ахлах зааварлагч байсан одоо Фрунзийн районы зэвсэгт хүчний дайчид, хөдөлмөрийн ахмадууд зөвлөлийн гишүүн, бэлтгэл хурандаа А. Д. Чепарукин, бидний дарга багш-орчуулагч байсан одоо ОХУ-ын Бөлгород хотод байгаа Ч. Бумбужеев нарын бидний тухай гаргасан лавлагаас иш татвал тус сургуульд Ц. Дэмиддагва, Л. Бэгз, Б. Цэвэгдорж, Б. Гунгаа Б. Дамбаасүрэн, Г. Жүгдэр, А. Мижид нар 1940 оны 12 дугаар сараас 1943 оны 3 дугаар сар хүртэл суралцаж сургуулиа төгсөөд

буцсаныг баталж байна. Эдгээр суралчид фашист Германы зөвлөлтийн ард түмний аугаа их эх орны дайны анхны өдрөөс эхлэн 1941 оны 10 дугаар сар хүртэл бүтэн гурван сарын турш сургуулийн бие бүрэлдэхүүний хамт Баруун өмнөд фронтын хамгааны журамд шилжиж, Харьков хотыг хамгаалах болон коммунистын бэхлэлт хийх, агаарын дайсантай тэмцэх ажилд маш их хувь нэмэр оруулж байв. Мөн өдөр шөнийн ямар ч нөхцөлд байлдааны албанд гарч хээрийн харуул, засагд ажиллаж дайсны эсрэг суралчид Харьковт болон Ташкентад суралцах хугацаандаа их хурал баатарлаг байж, өөрийн үүргийг нэр төртэй биелүүлэхийн тулд хилээ үзүүлж, Монгол-Зөвлөлтийн хилчдийн найрамдал, найрамдлын ажиллагааг бэхжүүлэх, нийтийн дайсны эсрэг хамтын тэмцэлд хувь нэмэр оруулсан юм..." гэжээ.

Дайны II дайнд фашизмыг ялсны 50 жилийн ойг 1995 онд хуучин бүрэлдэхүүнд багтаж байсан олон үндэстэн ястнууд бүх хүн төрөлхтний хамт өргөн тэмдэглэсэн нь зүй ёсны хэрэг юм. Дайны үед ард түмэн өөрийн ядуу зүдүүг үл хайхран чадлынхаа хэрээр дайны эсрэг байсныг санахад сайхан байна.

1995 он

М. Дүгэрсүрэн

Они бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

ЭРГЭН САНАХАД

1. АЗ ТУШСЭН МИНЬ

Дайны хувьсгалын 25 жилийн ойн наадмын дараахны нэг орой, бидний саях суралцахаар болсон бидний зургаан хүнийг тэр үед бидний даамны орлогч сайд байсан Нянтайширын Лхамсүрэн, бидний хэлтсийн нь дарга байсан Ламын Дармаа нар Сонгинын дайны нэг жилий төглөөс үдэн гаргаж билээ.

Тэр үед полуторжа гэж нэршсэн (бүтэн хагас тоннын даацтай) машин-аар зөвлөлтийн нутагт хүрч төмөр замд суухаар гарахад бидний жаал зугаа юмсын хамт 3 хайрцаг цөцгийн тос аччихсан бидний даамны дараах ховор үед замдаа явахад, мөн Москва очсоны өдөр хэсэгтээ бидэнд их тус болсныг мартдаггүй юм.

Сонгинын Аварзэд, Шагдарын Бира, Мангалын Дүгэрсүрэн,